# Хөдөлмөрийн зах зээл



Ямар нэгэн ашигтай үр дүнд хүрэхэд чиглэгдсэн хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг хөдөлмөр гэдэг.

# Зах зээл







***Ажиллах хүчний арилжаа, солилцоо хийж буй хүрээг хөдөлмөрийн зах зээл гэнэ.***



**Хөдөлмөр**

- **Биеийн хүчний хөдөлмөр:** бие махбодын үйл ажиллагаа давамгайлсан хөдөлмөрийг хэлнэ.
- **Оюуны хөдөлмөр:** оюун ухааны үйл ажиллагаа давамгайлсан хөдөлмөрийг хэлнэ.

# 1. Хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт




*График 1.1. Хөдөлмөрийн эрэлтийн муруй*
*W(wage)-цалин*




*График 1.2. Хөдөлмөрийн нийлүүлэлтийн муруй*
*L(Labor)-Хөдөлмөрийн тоо хэмжээ*

цалин өсөхөд байгууллагын зардал нэмэгдэж, ашиг буурах тул ажил олгогчоос олон ажилтан авч ажиллуулах сонирхол буурна.

цалин буурахад хөдөлмөрийн эрэлт өснө.

| Цалин (төгрөг) | Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажил хайгчийн тоо | Хөдөлмөрийн эрэлт буюу ажиллах хүчний тоо | Илүүдэл (+) Хомсдол (-) |
|---|---|---|---|
| 200000 | 100 | 500 | -400 |
| 300000 | 200 | 400 | -200 |
| 400000 | 300 | 300 | = |
| 500000 | 400 | 200 | +200 |
| 600000 | 500 | 100 | +400 |

| Хөдөлмөрийн эрэлт | Хөдөлмөрийн нийлүүлэлт |
|---|---|
| Цалингаар баталгаажсан ажиллах хүчний хэрэгцээ, шаардлага | Хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд бэлэн байгаа төрөл бүрийн мэргэжилтэй ажиллах хүчний тоо |



40.1.3Монгол Улсад 15-59 насны хүн амыг “Хөдөлмөрийн насны хүн ам” гэнэ гэж Хөдөлмөрийн тухай хуульд заажээ.




Ажиллах хүч (эдийн засгийн идэвхтэй хүн ам)
Хөдөлмөр эрхэлж байгаа иргэд
Бүртгэлтэй, хөдөлмөр эрхлээгүй иргэд

Ажиллах хүчийг эдийн засгийн идэвхтэй хүн ам гэдэг. Үүнээс гадна эдийн засгийн идэвхтэй бус хүн ам гэсэн ойлголт байдаг.

Идэвхтэй бус хүн амд 16 хүртэлх насны хүүхдүүд, тэтгэврийн насны хүн ам, ажил эрж хайхаа больсон хүмүүс багтдаг.

# Ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг тооцох

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{(Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо)}}{\text{(Хөдөлмөрийн насны хүн амын тоо)}} \times 100\%$$

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Хөдөлмөр эрхэлж буй хүний тоо}}{\text{(Хөдөлмөрийн насны хүн амын тоо)}} \times 100\%$$

# Хөдөлмөрийн зах зээл дараах үүрэгтэй. Үүнд:

- Ажиллах хүчийг бэлтгэнэ.
- Орлогын боломжийг бий болгоно.
- Хөдөлмөрийн нийлүүлэлт ба хөдөлмөрийн эрэлтийг зохицуулна.

| Мэдэж авсан зүйл | Мэдэж байсан зүйл | Мэдэхийг хүсч байгаа зүйл |
| --- | --- | --- |
| | | |